

Монгол Улсын Үндэсний аудитын газар

ҮАГ

**2004 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлан**

**ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ
НОГДОЛ АШИГ БҮРЭН
ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙНА**

**Хувьцааны ногдол ашиг,
өмч хувьчлалын орлогын
бүрдүүлэлт**

Улаанбаатар
2004 оны 11 дүгээр сар

ҮАГ-1/2004/08-ГА

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	3
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	4
	Аудит хийхэд учирсан хүндрэл, бэрхшээл	4
Аудитын дүн	Өмч хувьчлалын орлогын бүрдүүлэлт	5
	Хувьцааны ногдол ашгийн бүрдүүлэлт	6
	Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг төсөвт төвлөрүүлэхэд тавьж буй хяналтын талаар	11
Дүгнэлт		13
Холбогдох байгууллагын санал	Сангийн яам	15
	Үндэсний татварын ерөнхий газар	16
Зөвлөмж		18
Хавсралт	№ 1 Аудитад хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 2003 оны ногдол ашгийн төвлөрүүлэлт	20
	№ 2 2003 онд алдагдалтай ажилласан аж ахуйн нэгжүүд	
	№ 3 2003 онд ногдол ашиг төлөхөөс чөлөөлөгдсөн байгууллагууд	
	№ 4 2003 онд ашигтай ажилласан, аудитад хамрагдаагүй ногдол ашиг төлөх байгууллагууд	
	№ 5 2003 оны өмч хувьчлалын орлогын бүрдүүлэлт	

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Үндэсний аудитын газрын 2004 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Улсын төсвийн татварын бус орлогын нэг эх үүсвэр болох төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн тодорхойлолт, төвлөрүүлэлт, өмч хувьчлалын орлогын бүрдүүлэлтийг 2003 оны байдлаар шалгаж дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төрийн өмчид ногдох ногдол ашгийг төсөвт төлбөл зохих 9 хамтарсан үйлдвэр, төрийн өмчийн оролцоотой хувьцаат 15 компани, төрийн өмчит хувьцаат 24 компани, төрийн өмчит үйлдвэрийн 33 газар, нийт 81 аж ахуйн нэгж байна.

Аудитад 2003 онд хувьчлагдсан аж ахуйн нэгж, объектууд болон хамтарсан 4 үйлдвэр, төрийн өмчийн оролцоотой хувьцаат 1 компани, төрийн өмчит хувьцаат 14 компани, төрийн өмчит үйлдвэрийн 16 газар, бүгд 35 аж ахуйн нэгж хамрагдлаа.

Дээрх аж ахуйн нэгжид аудитыг явуулахдаа гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан Санхүү, эдийн засгийн яам, Төрийн өмчийн хороо, Үндэсний татварын ерөнхий газраас авсан судалгаа, мэдээлэл, түүнтэй холбоотой баримт материалд дүн шинжилгээ хийж, холбогдох зарим газруудаас судалгаа лавлагаа авч, биечлэн очиж тулган үзэж, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Дараахь хууль тогтоомжийн заалтыг энэхүү аудитад шалгуур болгон ашиглав. Үүнд:

- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.64 дэх заалт
 1. Төрийн өмчийг хувьчлах явцад авсан бүх төрлийн хураамж, хувьчлагдсан эд хөрөнгийн үнэ, энэ зориулалтаар бусдаас төрд өгсөн хандиваас хувьчлалын орлого бүрэлдэнэ.
 2. Хувьчлалын орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулна.

Ерөнхий зүйл

- ❖ Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 13 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг тооцож, төсөвт төвлөрүүлэх нийтлэг журам”
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2 дахь заалт “Санхүүгийн тайлан үнэн зөв баримт материал, бодит тоо мэдээнд үндэслэх;”
- ❖ Компанийн тухай хуулийн 13.94 дэх заалт “Компани нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах бөгөөд түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.”

Аудитын
стандартын
талаарх
мэдэгдэл

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Гүйцэтгэлийн аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр хэлтсийн дарга Д.Ганбилэг удирдаж, тус хэлтсийн ахлах аудитор Л.Одгэрэл, аудитор С.Андруш, шинжээч Ц.Эрдэнэчулуун, Б.Саруул нар 2004 оны 8 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 1-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Аудит хийхэд
учирсан
хүндрэл,
бэрхшээл

Үндэсний татварын ерөнхий газар, Төрийн өмчийн хорооноос гаргаж өгсөн мэдээ судалгаанууд хоорондоо зөрүүтэй байснаас ногдол ашгийн ногдуулалт, төлөлтийг шалгахад хүндрэлтэй байлаа.

Ногдол ашиг төвлөрүүлэх талаархи тушаал, шийдвэр тухайн байгууллагад ирээгүй, хувийн аудитын компани аудитыг зохих шаардлагын хэмжээнд хийгээгүйгээс байгууллагын 2003 оны тайлан тэнцлийг нарийвчлан шалгаж хугацаа алдсан болно.

Аудитын дүн

Өмч хувьчлалын орлогын бүрдүүлэлт

2003 онд нийтийн дуудлага худалдаагаар 14, түрээсийн давуу эрхээр 7, уралдаант шалгаруулалтын аргаар 8, менежментийн үр дүнг харгалзан хувьчилсан 4, хөрөнгийн биржээр арилжаалагдсан 1, бүгд 34 аж ахуйн нэгж, объектыг худалдаж, улсын төсөвт 30384231,1 мянган төгрөгийн өмч хувьчлалын орлого орохоос Төрийн өмчийн хороонд 26629679,8 мянган төгрөг орсон байна.

Орлогын 26575979,8 мянган төгрөг Төрийн өмчийн хорооны дансанд төвлөрч, 53700,0 мянган төгрөг ягаан тасалбараар дуудлага худалдаа хийгджээ.

2003 оны өмч хувьчлалын орлогын дутуу 3754551,3 (30384231,1-26629679,8) мянган төгрөг нь менежментийн үр дүнг харгалзан хувьчилсан Налайхын Дулааны цахилгаан станцын 365134,1 мянган төгрөг, Хүмүүнлэгийн их сургуулийн 1150000,0 мянган төгрөг, Улаанбаатар их сургуулийн 412417,2 мянган төгрөг, уралдаант шалгаруулалтын аргаар хувьчилсан Эмийн үйлдвэрийн 621600,0 мянган төгрөг, нийтийн дуудлага худалдаагаар хувьчилсан Анхны анжис ХХК-ий түрээсээр эзэмшиж байсан барилгын 55400,0 мянган төгрөг төлөгдөх хугацаа болоогүйтэй холбоотой байна. Харин Багануурын дулааны цахилгаан станцын 1150000,0 мянган төгрөг шүүхийн шатанд хянагдаж байгаа тул төлөөгүй үлдэгдэл хэлбэрээр байна.

2003 онд Төрийн өмчийн хороо өмч хувьчлалын орлогоос 19355109,4 мянган төгрөгийг улсын төсөвт шилжүүлсэн байна.

ТӨХ өөрт төвлөрсөн орлогоос улсын төсөвт 7220870,4 (26575979,8-19355109,4) мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсний 6780200,0 мянган төгрөгийг Монгол даатгал ХХК 2004 оны 1 дүгээр сарын 7-д шилжүүлснээс, Хүмүүнлэгийн их сургуулийн 100000,0 мянган төгрөг, Улаанбаатар их сургуулийн 100000,0 мянган төгрөг, Налайхын Дулааны цахилгаан станцын 40570,4 мянган төгрөг, Эмийн үйлдвэрийн 100000,0 мянган төгрөг, Худалдаа үйлдвэрийн дээд сургуулийн 100100,0 мянган төгрөгийг буцааж өгөх дуудлага худалдааны дэнчин тул үлдээсэн байна. Хувьчилж авсан дээрх 5 байгууллагын дэнчингийн 440670,4 мянган төгрөг ТӨХ дансанд зохих эрхийн акт, шийдвэргүй хадгалагдаж байна.

Аудитын дүн

Хувьцааны ногдол ашгийн бүрдүүлэлт

Ногдол ашиг төлөх ёстой 81 аж ахуйн нэгжийн 43,2 хувь буюу 35 аж ахуйн нэгжид аудит хийхэд 2003 оны ашгаас 1735679,6 мянган төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээс 2003,2004 онд 1129681,0 мянган төгрөг төвлөрүүлжээ.

Аудитын явцад 13343,4 мянган төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлж, 8 аж ахуйн нэгжид 282261,3 мянган төгрөгийн ногдол ашиг төлөх акт тогтоов.

❖ Хамтарсан үйлдвэрийн талаар

2003 онд ХҮ- үүдээс Монголчехметалл , Монголросцветмет нэгдэл, Улаанбаатар төмөр зам, Монголын цахилгаан холбоо, Монголболгаргео, Эрдэнэт үйлдвэр ашигтай ажилласан байна.

Аудитад Монголросцветмет нэгдэл, Монголын цахилгаан холбоо, Монголчехметалл, Монсам ХҮ-ыг хамрагдав.

Монголросцветмет нэгдэл 306000,0 мянган төгрөгийн ногдол ашиг төлөх ёстой боловч хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэгдээгүйгээс төлөөгүй байна.

Монсам ХҮ нь 1995 онд БНСУ-ын “Шина” корпорацийн 20 хувийн, Монгол улсын төрийн өмчийн 80 хувийн хөрөнгө оруулалт, БНСУ-ын Экспорт импорт банкны 4123,0 сая воны урт хугацаат зээлээр байгуулагджээ.

Тус компани урт хугацаат зээлийг анх авч байхад 1 ам.долларын ханш 439 төгрөгтэй, воны ханш 0,54 төгрөгтэй тэнцэж байсан бол тайлант үеийн байдлаар 1 ам. долларын ханш 1185 төгрөг, воны ханш 1,02 төгрөг болж, валютын ханшийн уналтаас шалтгаалан зээлийн үндсэн төлбөр болон хүүг төлөхөд алдагдал хүлээсэн, мөн бүтээгдэхүүний үнэнд 1997 оноос хойш жижиглэнгийн үнийн өөрчлөлт хийгээгүй, бүтээгдэхүүний өртөг, борлуулах үнээс давснаас шалтгаалан 2003 онд 462057,8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Монсам ХҮ 2003 оны эцэст зээлийн хүүгийн өглөг 101109,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Монголчехметалл, Монголын Цахилгаан холбоо ХҮ нь төсөвт төвлөрүүлэх 2003 оны ногдол ашгийг бүрэн төлсөн байна.

Аудитын дүн

❖ Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани (ТӨОХК)-ий талаар

2003 онд ТӨОХК-аас Багануур, Талын зам, Автозам Архангай, Харгуй, Дорнод автозам, Булган-Эрдэнэт Суварга компани ашигтай ажиллажээ.

Үүнээс Багануур компани ТӨОХК-ийг аудитад хамруулан шалгав.

Тус компани 2003 онд 587014,3 мянган төгрөгийн ашигтай ажиллаж, төсөвт төлөх ногдол ашиг 66069,2 мянган төгрөгийг төлөөгүй байсан тул төлүүлэх акт тогтоов.

❖ Төрийн өмчит хувьцаат компан (ТӨХК)-ий талаар

2003 онд ТӨХК-аас Монгол шуудан, Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТТТХТ), Эрдэнэзам, Дулааны хоёрдугаар цахилгаан станц, Дулааны гуравдугаар цахилгаан станц, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц, Дарханы Дулааны цахилгаан станц, Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц, Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ, Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ, Дарханы Дулааны станц, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ компани ашигтай ажилласан байна.

Аудитад Монгол шуудан, ҮЦТТТХТ, Эрдэнэзам, Дулааны хоёрдугаар цахилгаан станц, Дулааны гуравдугаар цахилгаан станц, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц, Дарханы Дулааны цахилгаан станц, Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ (БЗӨБЦТС) Дарханы Дулааны станц, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ компани (ТБДДС), Авто зам засвар арчлалтын нэгдэл (АЗЗАН), Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ (УБЦТС), Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК хамрагдав.

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл, Дэд бүтцийн сайдын 2004 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 0/869 дүгээр удирдамж, Төрийн өмчийн хорооны 2004 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 83 дугаар тэмдэглэлийг үндэслэн Дулааны 2,3,4 дүгээр цахилгаан станцууд, Дархан, Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц, ТБДДС, Дарханы Дулааны сүлжээ,

Аудитын дүн

Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ, БЗӨБЦТС ТӨХК-уудын хувь нийлүүлэгчдийн 2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 5 дугаар хурлын тогтоолоор Ховдын цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд зориулж 2003 оны цэвэр ашгаас 350,0 сая төгрөг төвлөрүүлэхээр тогтоосноос 4 ТӨХК 138,0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрсэн тул нөхөн төлүүлэх акт тогтоов.

ҮЦТТТХТ, Эрдэнэзам ТӨХК 2003 оны ногдол ашигт 5457,0 мянган төгрөг төлөөгүй байсныг төлүүлээ.

АЗЗАН ТӨХК 2002 онд мянган төгрөгийн ашигтай ажиллаж 4300,0 мянган төгрөгийн ногдол ашиг төлөхөөс 2003 онд 2000,0 мянган төгрөгийг төлж 2300,0 мянган төгрөг төлөөгүй байсан тул төлүүлэх акт тогтоов.

❖ Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ)-ын талаар

2003 онд ТӨҮГ-уудаас Дарханы Төмөрлөгийн үйлдвэр, Цахилгаан шуудан холбооны газар, Аэрогеодезийн үйлдвэр, Хот байгуулалт, Бөртэ, Геологийн төв лаборатори, Дэд бүтцийн ажилтны мэргэшил дээшлүүлэх институт, Иргэний нисэхийн ерөнхий газар, Тамга тэмдгийн үйлдвэр, Биокомбинат, Зураг зүйн үйлдвэр, Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газар, Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв, Сорьцын улсын хяналтын алба, Газрын тосны Хэрэг эрхлэх газар ашигтай ажилласан байна.

Аудитад Биокомбинат ТӨҮГ-аас бусад нь хамрагдлаа.

ТӨҮГ-уудаас 5 байгууллагын 7886,4 мянган төгрөгийн ногдол ашгийг аудитын явцад төлүүлж, Дарханы Төмөрлөгийн үйлдвэр, Бөртэ, Тамга тэмдгийн үйлдвэр ТӨҮГ-т нийт 78192,1 мянган төгрөгийг төлүүлэхээр акт тогтоов.

❖ Ногдол ашиг төлөхөөс чөлөөлөгдсөн аж ахуйн нэгжүүдийн талаар

2003 онд ашигтай ажилласан ТӨҮГ 9, ТӨХК 1, ХҮ 1, бүгд 11 аж ахуйн нэгжийг ногдол ашиг төлөхөөс чөлөөлсөн байна.

Үүнд:

- Шижир алт ХҮ нь төрийн өмчийн 26 хувийн оролцоотой тул Төлөөлөн удирдах зөвлөлийн

Аудитын дүн

шийдвэрт төрийн оролцооны хувиар нөлөөлөх бололцоогүй;

- Диспетчерийн үндэсний төв ТӨХК нь эрчим хүчний аж ахуйн нэгжүүдэд зохицуулсан эрчим хүчнээсээ шимтгэл авч ажилладаг;
- Хөдөө аж ахуйн техникийн корпораци, Хөрөнгийн бирж, Эрчим корпораци, Цагаан шонхор, Барилга архитектор корпораци ТӨҮГ-ын ашгийн хэмжээ 85,8-931,2 мянган төгрөг байгаа тул 1,0 сая төгрөг хүртэлх ашигтай аж ахуйн нэгжүүдэд ТӨХороо ногдол ашиг тооцоогүй;
- Барилгын цэргийн 022 дугаар анги, Сүүж уул амралт нь харъяа яам газартай гэрээтэй;
- Сэргээгдэх эрчим хүч корпораци, Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс төлбөрийн чадвар муутай тул ногдол ашиг хуваарилах бололцоогүй гэж үзжээ.

❖ Ногдол ашгийн тооцооллын талаар

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 145 дугаар тогтоолоор Улсын циркийг 2002 оноос эхлэн төсөвт байгууллагын хэлбэрээр ажиллуулахаар шийдвэрлэсэн боловч Төрийн өмчийн хорооны 2004 оны 176 дугаар тогтоол, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 102 дугаар тушаалаар 15 хувиар 5671,2 мянган төгрөгийн ногдол ашиг ногдуулсан байна.

Аудитад хамрагдсан аж ахуйн нэгжүүд хувийн аудитын компаниар жилийн эцсийн тайлан тэнцэлд аудит хийлгэсэн боловч зарим аж ахуйн нэгжийн доорх зөрчлийг илрүүлээгүй байна.

2003 оны ногдол ашгийн тооцооллыг шалгах явцад тухайн байгууллага цэвэр ашгаа алдаатай буруу тодорхойлсон зөрчил илрэв. Тухайлбал:

- АЗЗАН ТӨҮГ -ын 2002 оны ногдол ашгийн 2300,0 мянган төгрөг төлөгдөөгүй байсныг аудит хийсэн байгууллага төлүүлэх талаар зөвлөмж өгөөгүй.
- ТБЦДС ТӨХК 2003 оны үйл ажиллагааны бус зардалд 2002 оны татвар ногдуулах орлогыг буруу тооцсоноос татварын байгууллагаас актаар тавигдсан 46282,1 мянган төгрөгийг оруулан

Аудитын дүн

тооцож, энэ хэмжээгээр тайлант үеийн цэвэр ашгийг дутуу гаргажээ.

- УБЦТС ТӨХК 2003 онд тайлан тэнцлээр 343955,9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар 88429,3 мянган төгрөгийн ашигтай гарчээ. Гэтэл татвар ногдуулах орлогоос хасагдах зардлыг тооцохдоо 2003 оны зардалд бүртгэгдэхгүй 29218,8 мянган төгрөгийг оруулан тооцсоноос татвар ногдох орлогыг энэ хэмжээгээр бууруулсан байна. Дутуу тооцсон аж ахуйн нэгжийн орлогын татвар 6574,2 мянган төгрөгийг төлүүлэх акт тогтоов.

Тус компани нягтлан бодох бүртгэлийн бодлого байхгүйгээс дансны бичилтийг өөр өөрөөр бүртгэн буруу бичилт хийж байна. Үүнд:

- Төрийн өмчийн хорооны 2003 оны 650 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн орлогод авахдаа Зуунмод ЭХСалбар “Бусад орлого” данснаас, Сүхбаатар ЭХСалбар “Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг” данснаас тус тус бичилт хийжээ.
- УБЦТС ТӨХК-ий хэмжээгээр 3201 дугаартай “Урьдчилж орж ирсэн орлого” дансны 2003 оны жилийн эцсийн үлдэгдлийг гаргахдаа энэ дансны дебетэд бичигдсэн гүйлгээний дүнг авлага дансанд бичихгүй кридет гүйлгээний дүнгээс хасч зөрүүгээр тайланд тусгажээ.
- Мөн 3901 дугаартай “Байгууллага хоорондын тооцооны хаалт” гэсэн дансанд буруу бичигдсэн гүйлгээг залруулан бүртгэдэг боловч зарим салбар, тухайлбал, Налайх ЭХСалбар байгууллага, хүмүүсийн 10777,1 мянган төгрөгийн өглөг, авлагыг хооронд нь зөрүүлэн хааж бичсэн байна.
- Төлөөлөн удирдах зөвлөлын хурлын 2003 оны 10 дугаар тогтоолд элэгдлээ бүрэн нөхсөн Налайх ЭХСалбарт ашиглагдаж байгаа 2 автомашиныг акталж өгөхийг хүссэний дагуу Төрийн өмчийн хорооны 2003 оны 311 дүгээр тогтоолоор актлан дуудлага худалдаагаар оруулж, 506,0 мянган төгрөгөөр үнэлэн худалджээ. Гэтэл эдгээр

Аудитын дүн

автомашинууд элэгдлээ бүрэн нөхөөгүй 3233,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба дуудлагаар худалдах үнийг тогтоохдоо үлдэгдэл үнийг тооцож үзээгүй байна.

- Шуудан цахилгаан холбооны газар ТӨҮГ нь 2003 онд 80601,2 мянган төгрөгийн ашигтай ажиллаж, ногдол ашиг 40300,6 мянган төгрөгийг төлжээ. 2003 оны жилийн эцсийн тайлан тэнцэлд 2003 оны түрээсийн орлого 11500,0 мянган төгрөгийг урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд бүртгэн үлдээжээ.

Ногдол ашгийг төсөвт төвлөрүүлэхэд тавьж буй хяналтын талаар

Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 13 дугаар тушаал “Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг тооцож, төсөвт төвлөрүүлэх нийтлэг журам”-д зааснаар ТӨХороо ТӨХК, ТӨҮГ-аас төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь, хэмжээний талаарх саналыг Санхүү, эдийн засгийн сайдад хүргүүлдэг бөгөөд уг саналыг үндэслэн Санхүү, эдийн засгийн сайд тушаал гаргадаг байна.

Харин ХҮ, ТӨОХК-ас төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг тэдгээрийн хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн хороо тогтоолоороо шийдэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийг Үндэсний татварын ерөнхий газар хариуцан төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээжээ.

Дээрх журмын хэрэгжилтийг шалгахад дараахь зөрчил илрэв.

Төрийн өмчийн хороо :

- Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 145 дугаар тогтоолоор Улсын циркийг 2002 оноос эхлэн төсөвт байгууллагын хэлбэрээр ажиллуулахаар шийдвэрлэснийг үл харгалзан мэдэлгүй цэвэр ашгаас 15 хувиар буюу 5671,2 мянган төгрөгийг ногдол ашигт төвлөрүүлэхээр 2004 оны 176 дугаар тогтоолдоо заажээ.
- Зарим аж ахуйн нэгж цэвэр ашгийн хэмжээг алдаатай тодорхойлсон байна. Тухайлбал: Тамга тэмдгийн үйлдвэр ТӨҮГ-ын 2003 оны цэвэр ашиг тайлан тэнцлээр 81362,7 мянган төгрөг, төлөх ногдол ашиг

Аудитын дүн

12204,0 мянган төгрөг байхад цэвэр ашгийг 68386,2 мянган төгрөг, ногдол ашгийг 10257,9 мянган төгрөг гэж тодорхойлжээ.

- Ногдол ашгийн төвлөрүүлэлтийн гүйцэтгэл бодит байдлаас ихээхэн зөрүүтэй байна. Тухайлбал: 2003 онд ногдол ашигт Багануур ТӨОХК 66003,0 мянган төгрөг, Хот байгуулалт ТӨҮГ 1857,1 мянган төгрөг, Геологийн төв лаборатори ТӨҮГ 1286,8 мянган төгрөг, Эрдэнэзам ТӨХК 4881,4 мянган төгрөг, Тамга тэмдгийн үйлдвэр ТӨҮГ 10257,9 мянган төгрөгийг төлөөгүй боловч төлснөөр мэдээ гаргажээ.
- Төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээний талаархи тогтоол, тушаалыг аж ахуйн нэгжүүдэд албан ёсоор хүргүүлээгүй, аудитад хамрагдсан ихэнх аж ахуйн нэгжүүд уг шийдвэрүүдийг олж үзээгүйгээс төвлөрүүлээгүй байна. Жишээлбэл: Бөртэ ТӨҮГ, ҮЦТТХТ, Тамга тэмдгийн үйлдвэр ТӨҮГ-т Төрийн өмчийн хорооны 2004 оны 176 дугаар тогтоол, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 102 дугаар тушаал хүргэгдээгүйгээс 2003 оны ногдол ашгийг төлөөгүй байна.
- Ногдол ашгийг бүрэн төвлөрүүлэхэд хяналт тавьдаггүй байна. Тухайлбал: АЗЗАН ТӨХК 2002 оны төлөх ногдол ашиг 2300,0 мянган төгрөгийг төлөөгүй байна.

Үндэсний татварын ерөнхий газар :

- 2003 оны ногдол ашгийн төвлөрүүлэлтийн талаар гаргасан мэдээ нь бүрэн биш, зөрүүтэй байна. Тухайлбал: Сорьцын УХА 2003 онд төлөх ногдол ашгийн хэмжээг 870,0 мянган төгрөг, 2003 онд 11000,0 мянган төгрөг төлснөөр гаргажээ. Гэтэл аудитаар төлөх ногдол ашиг 1586,2 мянган төгрөг, төлсөн нь 8000,0 мянган төгрөг байна. Мөн Багануур ТӨОХК-ий 2003 онд төлөх ногдол ашиг 62400,0 мянган төгрөг, төлсөн нь 62400,0 мянган төгрөг гэжээ. Аудитаар 66069,2 мянган төгрөгийн ногдол ашиг төлөхөөр тогтоосон бөгөөд үүнийг төлөөгүй байлаа.

Дүгнэлт

Аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, хийсэн ажиглалт, дүн шинжилгээнд тулгуурлан дараахь дүгнэлт хийж байна:

- Өмч хувьчлалын орлогын бүрдүүлэлт бүрэн хийгдэж 19355109,4 мянган төгрөг төсөвт төвлөрчээ.
- Төрийн өмчийн хороо хувьчилж авсан байгууллагуудын дэнчингийн мөнгө 440670,4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй өөрийн дансанд үлдээсэн байна.
- Аудитад хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 295604,7 / 282261,3+13343,4/ мянган төгрөгийн ногдол ашгийг хугацаанд нь төвлөрүүлээгүй, цэвэр ашгийн тооцооллыг буруу хийснээс төсөвт төлөх ногдол ашгийн хэмжээ дутуу тодорхойлогдож байна.
- Хувийн зарим аудитын компани тайлан тэнцэлд аудит хийхдээ зөрчлийг илрүүлж залруулах талаар дутмаг ажиллажээ.
- Ногдол ашгийг төсөвт төвлөрүүлэх талаар гарсан тогтоол, шийдвэрийг аж ахуйн нэгжүүдэд зохих хугацаанд нь хүргүүлээгүй байна.
- Аж ахуйн нэгжүүдийг ногдол ашиг төлөхөөс чөлөөлөх талаархи эрхийн акт тодорхой бус байна.
- ҮТЕГ Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 13 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг тооцож, төсөвт төвлөрүүлэх нийтлэг журам”-ын 4.1-д “төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийг ҮТЕГ хариуцаж төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Дээрх журмын 5.1-д “төрийн өмчийн ногдол ашгийн ногдуулалт, төлөлтөд ТӨХ хяналт тавина” гэсэн заалтыг ТӨХ бүрэн хэрэгжүүлээгүй, ногдол ашгийн тооцоолол, төлөлтийн мэдээ судалгааг үнэн зөв гаргаагүй байна.
- “Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг тооцож, төсөвт төвлөрүүлэх нийтлэг журам”-д ногдол ашгийн орлогын гүйцэтгэлийг Үндэсний татварын

Дүгнэлт

ерөнхий газар, Төрийн өмчийн хороо, Сангийн яамтай тооцоо нийлж харилцан баталгаажуулах талаар зааж өгөөгүйгээс эдгээр байгууллагуудын гаргасан тайлан мэдээ хоорондоо зөрүүтэй байна.

- ҮТЕГ дээрх журмын 4.4-д “ Хуулийн этгээд жилийн эцсийн тайлангаар ногдол ашгийн ... дутуу төлөлттэй гарсан бол дараа оны 2 дугаар улиралд багтаан нөхөн төлнө “ гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
- Аудитаар ногдол ашгийг төвлөрүүлээгүй болон дутуу төвлөрүүлсэн 8 байгууллагад 282261,3 мянган төгрөгийн акт тавилаа.

Холбогдох байгууллагын санал

Сангийн яамны
санал
ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Улаанбаатар, Төв замын 1/10-д
МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ
Улаанбаатар, Төв замын 1/10-д
Улаанбаатар, Төв замын 1/10-д

2007.12.07 № 207/2007
Санал 2007.12.07 өдөр № 207

Санал өгөх тухай

Танай газраас төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн тодорхойлолт, төвлөрүүлэлт, өмч хувьчлалын орлогын бүрдүүлэлтийг 2003 оны байдлаар шалгасан аудитын дүгнэлт, зөвлөмжийн төсөлтэй танилцаад дараах саналтай байна.

1 Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд ашигтай ажилласан бол ногдол ашиг төлөх ёстой. Харин ногдол ашгийг ямар хувь хэмжээгээр төлөх болон ногдол ашиг төлөхгүй байх тохиолдлуудыг нарийвчлан судалж, Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг тооцож, төсөвт төвлөрүүлэх нийтлэг журмыг д тусгах нь зүйтэй.

2 Үндэсний татварын ерөнхий газар нь "Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг тооцож, төсөвт төвлөрүүлэх нийтлэг журмын 4.1-д заасны дагуу хувьцааны ногдол ашгийн орлогыг төсөвт төвлөрүүлэх үүрэгтэй тул аудитын актаар баталгаажсан ногдол ашгийг энэ оны 12 дугаар сарын 15-ны дотор төсөвт төвлөрүүлэх талаар арга хэмжээ өмч хөрөгжүүлэх заалт намж оруулах саналтай байна. Ингэхдээ өмнөх оны ногдол ашгийн ногдуулалт, төлөлтийн тооцоог хийсний үндсэн дээр ногдол ашгийн дутуу төлөлтийг тухайн оныхоо 2 улиралд багтаан төсөвт төвлөрүүлэхээр заагдсан журмын 4.4 дэх заалтыг ч мөрдөж ажиллах асуудлыг хамтад нь тусгах шаардлагатай.

3 Төрийн өмч болон төрийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогын гүйцэтгэлийг Үндэсний татварын ерөнхий газар Төрийн өмчийн хороо Сангийн яамтай сар бүр тооцоо нийлж, хариуцаж, баталгаажуулж, Сангийн дээрх байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосон заалт нийлэх.

Цаашинд Төрийн өмчийн хороо ногдол ашгийн ногдуулалт, төлөлтөд хяналт гавьж, Үндэсний татварын ерөнхий газартай хамтарч ажиллахаас гадна төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад ногдол ашгийн орлогыг кутацаанд нь төвлөрүүлэх үүрэг, даалгавар өгч, төлөлтийг хангуулахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.



САНГИЙН ЯАМЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР
Ч.ХҮРЭЛБААТАР

08 0491

Холбогдох байгууллагын санал

Үндэсний
татварын
ерөнхий газар


МОНГОЛ УЛСЫН АЗЫН ТӨСВИЙН АЖИРААГАЙН ХАМГААГАХ
ҮНДЭСНИЙ
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
Улаанбаатар, 2004
Холбогдох байгууллагын санал
Төлөгч: 12.04 № 12/03
Тайлан: 2007.09.09 № 377

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай газраас төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газруудын 2003 оны ногдол ашгийг төсөвт төвлөрүүлж буй ажлын үр дүнг шалгасан гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаад дараах саналтай байна.

Үүнд

1. Төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газруудын ногдол ашгийг төв, орон нутгийн татварын албад хариуцан жил жилийн тайлангийн үр дүнгээр нь тооцон, төсөвт төвлөрүүлэх ажлыг гүйцэтгэж байгаа хэдий ч орон нутагт ажилладаг төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын ногдол ашгийг орон нутгийн төсөвт оруулан зарцуулах (Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Бөртэ компани, Тамга тэмдгийн үйлдвэр гэх мэт) ялангуяа төрийн өмчийн оролцоотой хувьцаат компаниудын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн хороо тайлангийн дараа оны дундуур хянан шийдвэрлэдэг зэрэг шалтгаангаар уг орлогыг төсөвт бүрдүүлэх ажилд цаг хугацаа алдаж байна. Үүл ажиллагааны үр дүнгээс авах ногдол ашгийг тэдгээрийн урьд онд мөрдөж байсан ногдол ашгийн хувь хэмжээ болон ойролцоо жишгийг баримтлан төсвийн жилд нь тооцож авахаар бодож ирэх оны төсөвт нь тусган УИХ-аас төсвийн төслийг хуульчлан баталдаг боловч ногдол ашиг авах эрх эйн үндэс бүрдээгүй, тооцох хувь хэмжээ нь тайлангийн дараа онд шийдвэрлэгддэг учраас төсөвт тусгагдсан ногдол ашгийн орлого төсвийн жилдээ багтаж төрийн санд орох боломжгүй байдаг бөгөөд тухайн жилд ногдол ашгаар төсөвт орсон орлогын гүйцэтгэл нь тэдгээр байгууллагуудын урьд онуудын дутуу төлөлт, зарим урьдчилгаа төлбөрүүдээс бүрдэж байгааг аудитын тайланд тэмдэглэх.
2. Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд "2003 оны ногдол ашгийн төвлөрүүлэлтийн талаар гаргасан мэдээ нь бүрэн биш, зөрүүтэй байна" гэжээ. Төрийн өмчийн хорооны 2004 оны 176 дугаар тогтоол, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 102 дугаар тушаал харьяалагдах татварын албадад хүргэгдээгүйгээс Бөртэ ТӨҮГ, ҮЦТТХГ, Тамга тэмдгийн үйлдвэр 2003 оны ногдол ашгийг төлөөгүй, түүрчлэн АЗАН ТӨХК 2002 онд төлөх ногдол ашиг 2360,0 мянган тугрийн орлогыг төсөвт


07.09.07

Холбогдох байгууллагын санал

Төвлөрүүлээгүй нь үнэн байх тул харьяалагдах татварын албадаар ногдуулалтыг нөхөн хийлгүүлж, уг орлогыг төвлөрсөн төсөвт оруулах ажлыг он дуусталх хугацаанд шуурхай хийж гүйцэтгэх болно.

3. Улсын төвлөрсөн төсөвтэй харьцдаг Сорцын хяналтын улсын алба, Багануур ХК, ТБЦДС ХК, УБЦТС хувьцаат компаниудын 2003 оны ногдол ашгийн ногдуулалтад Үндэсний аудитын газраас хийсэн шалгалтаар татварын байгууллагаас 2002 онд баримтын шалгалт хийж ажлаар тавигдсан төлбөрийн дээрх байгууллагууд 2003 онд үйл ажиллагааны зардалд оруулан татвар ногдол орлогыг бууруулах улмаар ногдол ашгийг дутуу тооцсоноос уг орлогыг төсөвт бүрэн аваагүй нь үндэслэлтэй байна. Төвлөрсөн төсвийн орлого, хяналтын газраас эдгээр байгууллагуудын 2003 оны үйл ажиллагаанд татварын графикт шалгалт хийх хугацаа болоогүй байснаас зөвхөн өөрсдийн нь ирүүлсэн татварын тайлангаар ногдол ашгийн тооцоог хийж байсан байна. Иймд тус газар дээрх зөрчлийг арилган, ногдол ашгийн тооцоог дахин хийж, орлогын дутууг онд нь багтаан төсөвт оруулна.

4. Үндэсний аудитын газраас ногдол ашгийн ногдуулалт, төвлөрүүлэлтийн талаар Үндэсний Татварын Ерөнхий Газрын удирдлагад өгсөн зөвлөмжтэй санал нэг байгаа бөгөөд цаашид төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнгээр төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг зөв тооцож, төсөвт оруулах талаар холбогдох арга хэмжээг авах болно.

ДАРГА 

Зөвлөмж

Улсын төсвийн татварын бус орлогын нэг эх үүсвэр болох төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн тодорхойлолт, төвлөрүүлэлт, өмч хувьчлалын орлогын бүрдүүлэлтийг 2003 оны байдлаар шалгасан аудитын дүгнэлтэд үндэслэн дараахь зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

Сангийн сайд Н. Алтанхуягт:

“Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг тооцож, төсөвт төвлөрүүлэх нийтлэг журам”-д дараах асуудлыг нэмж тусгаж өгөх; Үүнд:

- Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн тухайн жилийн ногдол ашиг төлөх хувь хэмжээ болон ногдол ашиг төлөхөөс чөлөөлөх тохиолдлыг нарийвчлан заах,
- Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийн орлогын гүйцэтгэлийг Үндэсний татварын ерөнхий газар, Төрийн өмчийн хороо, Сангийн яамтай сар бүр тооцоо нийлж, харилцан баталгаажуулж байх.

Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболдод:

- Хувьчилж авсан байгууллагын дэнчингийн мөнгийг хувьчлалын орлогод тооцон төсөвт төвлөрүүлэх;
- Аж ахуйн нэгж, компаний ногдол ашгийн төвлөрүүлэлтийн байдалд хяналт тавих, ногдол ашгийн хувь хэмжээ тогтоосон шийдвэрийг аж ахуйн нэгжүүдэд зохих хугацаанд нь хүргүүлж байх;
- Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 13 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг тооцож, төсөвт төвлөрүүлэх нийтлэг журам”-ын 5.1-д “төрийн өмчийн ногдол ашгийн ногдуулалт, төлөлтөд ТӨХ хяналт тавина” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

Үндэсний татварын ерөнхий газрын дарга Л.Зоригд:

- Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 13 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмч болон төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийг тооцож, төсөвт төвлөрүүлэх нийтлэг журам”-ын 4.1-д “төрийн болон орон

Зөвлөмж

нутгийн өмчийн ногдол ашгийг ҮТЕГ хариуцаж төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

- Дээрх журмын 4.4-д “ Хуулийн этгээд жилийн эцсийн тайлангаар ногдол ашгийн ... дутуу төлөлттэй гарсан бол дараа оны 2 дугаар улиралд багтаан нөхөн төлнө “ гэсэн заалтыг мөрдөж ажиллах;
- Аудитын актаар тогтоогдсон болон аудитад хамрагдаагүй байгууллагын 2003 оны ногдол ашгийн дутуу төлөлтийг 2004 онд багтаан бүрэн төвлөрүүлэх;

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 262071 дугаарын факсаар харилцана уу.

Тэргүүлэх аудитор

Д.Ганбилэг